

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ёндонжамц	Дугаар	L048
Оршин суугаа аймаг	Дорнод аймгийн	Оршин суугаа сум	Баяндун
Төрсөн газар	Дорнод аймгийн Баяндун сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Угтамтэгчэнллин хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029
Одоогийн сүм хийд	Угтамын хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 030
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8 сарын 9	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчэнлин хийд

Манай хийдийг сэргээн босгосон өвгөн багш Базаргүр байсан. Тэр хүн анх 8 настайдаа шавилаад 18 хүртлээ шавилан суужээ. Тэгсэн цаг үймээд ирэхээр хувилгаан багш нь дуудаад за миний шавь цаг цөвүүн боллоо. Хар бол оо. Хэзээ нэгэн цагт шашин мөхөөд дахин сэргэнэ. Тэр үед чи хийдийнхээ утааг нь уугиулж хурал номыг нь Цогчиныг нь сэргээгээрэй гэж хэлж байсан гэдэг. Өвгөн багш тэр үед хувилгаан багш маань зөнөж дээ гэж бодож байсан гэдэг. 1990 оны 11 сард хийдээ сэргээж хурлаа хурж байсан тийм түүх байна. Бид чинь энэ хийдэд хүүхэд байхаасаа шавилсан. Биднийг бага байхад хийдийн гороо тойроод нохой хуцдаг байсан юм. Тэгээд нохой сэтэрлэснээс хойш больсон. Зүүн хойно хөх бүх мөөрдөг байсан гэдэг. Дамдин Чойжоо бурханы сэтэртэй. Ямаа майлдаг байсан гэсэн. Зуны эхэн сарын 15 –нд Баруун Хөх чулуунд лам нар ном уншиж байгаа юм шиг дуу гардаг. Яг үүрээр. Бид нар үүрээр эрт босоод сонсдог байсан. Баруун Хөх чулууг өвгөчүүл Рэгсүн Гомбын орон гэдэг байсан. Өвгөчүүл их сайхан сайхан түүх ярьдаг байсан юм. Уран Наваан гэдэг хүн байсан гэдэг. Уран Наваан ямар нэг юм хийх бол хийхийн өмнө заавал унтдаг. Унтаж байхдаа хийх санаагаа олж авдаг байсан тийм хүн байсан гэсэн. Модоор ямаа хийчихсэн. Тэр нь өөрөө явж очоод хийдийн баруун урд байдаг булгаас ус уугаад ирээд усаа өгдөг байсан гэдэг. Дорлигийн сэтэртэй хөх ямаа нь байдаг. Лам нар амраад хөдөөлдөг. Хөдөөлөөд ирэхээр заавал мөргөдөг байж. Тэр нь яаж байгаа юм гэхээр гай барцад, бузар дэвийг нь арилгаж байгаа. Тийм сонин сонин зүйл их байсан байгаа юм.